



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/004/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: У.Батчимэг Утас: 88094175 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
3.1 Төлбөрийн акт	12
3.2 ЗӨВЛӨМЖ	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	15
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	15
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.23 № 266
танай _____ -ны № _____ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЧИНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.2.2, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 37 дугаар зүйлийн 37.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5-д заасан заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд хөрөнгийн орлого, газрын төлбөр, малын тоо толгойн албан татварын орлого, улсын тэмдэгтийн хураамж, байгалийн нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр зэрэг орлогуудыг 33.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс тасарсан;
- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээ зохион байгуулаагүй;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажлуудаас захиалагчийн хяналтын зардлыг суутган тооцолгүй санхүүжилтийг бүрэн олгож, хяналт хэрэгжүүлээгүй 3.4 сая;
- Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд бүртгэлтэй 76.5 сая төгрөгийн зээлийн авлага, хувь хүнээс авах авлагуудыг барагдуулан ажиллаагүй тооцооны үлдэгдлийн баталгаа хийгээгүй;

8426959650

- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн морины барианы засварын ажилд 16.9 сая, Жаргалант багийн контор барих 59.8 сая нийт 76.8 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй,
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлуудын гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож, хөтөлбөр боловсруулан батлан ажиллах, хүрэх түвшин хүрсэн түвшинг тухай бүр хэлэлцээгүй, өмнөх СТА-аар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй дотоод хяналт хэрэгжүүлээгүй ажиллаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Чандмань сум нь "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн" одонгоор шагнагдсан Ховд аймгийн анхны сум болсон, малын тоогоороо аймагт 1 дүгээр байр, сум ажлын үзүүлэлтээрээ 5 дугаар байр тус тус шалгарчээ.

2025 онд тус сумаас хөдөлмөрийн баатар 1, гавьяат цолтон 6, улсын аварга малчин 1, алтан төлийн эзэн 1, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 8, Алтан гадас одонгоор 38 хүн шагнагдсан үзүүлэлттэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд түүхэн 100 жилийн ойгоо тэмдэглэн ойн үйл ажиллагаатай холбоотой үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө 263.4 сая төгрөг, 184.8 сая төгрөгийн бараа материал данс бүртгэлд бүртгэсэн, нэмэлт санхүүжилтийн дансаар 653.0 сая төгрөгийг орлого бүрдүүлэн зарцуулж 73.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

Бусад асуудлын хэсэг

ОНХС-ийн журамд заасны дагуу сангийн хөрөнгийн 42 хувийг сумын 100 жилийн ойн баярын үйл ажиллагааны урсгал зардалд төлөвлөн зарцуулсан нь Сангийн сайдын 2015 оны 86 дугаар журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,052,062.89	1,066,709.91
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	586,255.52	488,871.76
3	1.1.3 АВЛАГА	305,372.63	385,148.13
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	33,850	38,878.4
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	126,584.73	125,223.61
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	0.0	28,588
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,105,367.76	4,806,005.91
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,105,367.76	4,806,005.91
9	1.2.2.02 Биет хөрөнгө	4,041,438.76	4,742,076.91
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	63,929	63,929
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	5,157,430.65	5,872,715.82
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,618.68	191,506.47
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,618.68	176,506.47
14	2.1.1.03 Өглөг	28,618.68	176,506.47
15	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,000	15,000
16	2.1.2.02 Урт хугацаат зээл	15,000	15,000
17	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,113,811.97	5,681,209.35
18	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	5,113,811.97	5,681,209.35
19	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	994,353.98	994,353.98
20	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	3,865,895.93	4,433,662.35
21	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	253,562.07	253,193.02
22	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	5,157,430.65	5,872,715.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,461,319.48	4,698,285.08
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	661,255.51	625,089.46
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	504,459.35	465,477.75
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	519,083.64	485,878.73
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,624.3	-20,400.97
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	140,659.02	149,451.96
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	16,137.14	10,159.75

**Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	728,933.52	4,073,195.62
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,990,974.57
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,071,130.46	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,614,096.62	3,956,759.71
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,614,096.62	3,735,376.7
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,534,235.65	3,732,959.2
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,643.15	995,481.49
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,601.04	133,468.96
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	500,417.75	514,337.71
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	676,003.05	949,207.4
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	5,053.7	840.2
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	17,236.07	11,461.4
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	10,612	9,833.95
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,878.61	17,070.29
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	312,790.28	1,101,257.81
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,860.97	2,417.5
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	221,383.01
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	847,222.86	741,525.37
26	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	174,128
27	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	0.0	-174,128
28	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	847,222.86	567,397.37

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,834,964.16	3,176,802.62
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	661,255.51	625,089.46
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	504,459.35	465,477.75
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,624.3	-20,400.97
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	140,659.02	149,451.96
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	16,137.14	10,159.75
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,182.6	2,439.1
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	7,123.54	6,465.65
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	831	1,255

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,578.2	2,551,713.15
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	102,578.2	37,547.88
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,990,974.57
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	523,190.7
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,071,130.46	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,699,221.4	1,994,054.34
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,699,221.4	1,994,054.34
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,619,360.43	1,991,546.84
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,951.27	996,340.12
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,033.8	124,553.88
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	499,856.1	512,414.2
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	38,452.9	27,793.3
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	5,053.7	461.6
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	12,125.36	11,856
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	10,572	9,833.95
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,110.3	20,250.57
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	51,205	288,043.24
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,860.97	2,507.5
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,135,742.77	1,182,748.28
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	843,913.96	1,266,202.04
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	843,913.96	1,266,202.04
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	843,913.96	1,266,202.04
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-843,913.96	-1,266,202.04
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	13,196.52	13,930
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-13,196.52	-13,930
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	278,632.3	-97,383.76

**Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	307,623.23	586,255.52
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	586,255.52	488,871.76

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,266,549.67	4,266,549.67
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	39.45	39.45
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,266,589.12	4,266,589.12
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	847,222.86	847,222.86
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,113,811.97	5,113,811.97
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,113,811.97	5,113,811.97
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	369.04	369.04
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,114,181.02	5,114,181.02
9	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-369.04	-369.04
10	1.7 Тайлант үеийн үр дүн	567,397.37	567,397.37
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,681,209.35	5,681,209.35

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,537,181.60	2,486,214.35
2	11	3.1.01.1.1 Татварын орлого	609,798.50	625,089.46
3	110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	435,301.90	465,477.75
4	1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	455,702.90	485,878.73
10	1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,401.00)	(20,400.97)
12	113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	160,600.00	149,451.96
16	118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	13,896.60	10,159.75
17	1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,500.00	2,439.10
21	1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	9,496.60	6,465.65

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

23	1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	900.00	1,255.00
27	12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,927,383.10	1,861,124.88
28	120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	103,806.00	37,547.88
32	122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,300,386.30	1,300,386.30
35	123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	523,190.80	523,190.70
37	II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,998,294.40	2,657,228.65
38	21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,834,922.80	1,753,435.33
39	210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,830,132.70	1,750,927.83
40	2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	999,624.70	996,340.12
45	2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,565.60	124,553.88
51	2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	515,204.10	512,414.20
55	2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	34,870.10	26,685.70
59	2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	461.60
61	2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	12,742.70	11,856.00
64	2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	17,447.30	9,833.95
66	2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,045.00	18,275.90
73	2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	78,950.00	50,506.50
76	213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,790.10	2,507.50
77	2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,790.10	2,507.50
80	2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	4,790.10	2,507.50
83	22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,063,371.60	889,863.32
87	23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.00	13,930.00
89	8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		(171,014.30)
90	9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		171,014.30
91	7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	461,112.80	(171,014.26)
92	4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	583,278.32
93	5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	412,264.06

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	690,588.27
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	690,588.27
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	690,588.27
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	690,588.27
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	690,588.27
350011	1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	653,266.00
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,738.27
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,384.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,200.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	616,957.72
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	240,619.01
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,619.01
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,107.60
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,107.60
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,974.67
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,974.67
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	237,536.74
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	217,536.74
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000.00
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	376,338.72
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	376,338.72
223001	1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	376,338.72
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	73,630.55
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(73,630.55)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(73,630.55)

3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 453,692.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 296,555.9 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал болон өр төлбөр 45,772.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- ХХС-ийн зээлийн хүүгийн авлага бүртгээгүй 3,155.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЗДТГ-ын барилгын үнийн зөрүү 247,628.1 мянган төгрөг бүртгээгүй;

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 153,667.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 157,137.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 153,667.3 мянган төгрөгийн 6 заалт бүхий зөвлөмж, 3,469.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичлээ.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн наадмын талбайн ажлаас захиалагчийн техник хяналтын зардал, магадалшгүй ажлын хувь суутган тооцоогүй 3,469.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухайн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1-т “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;” 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Монгол Улсын Засгийн газрын 278 дугаар тогтоолын 5.3.1-т “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Орон нутаг хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Данс бүртгэлд бүртгэлтэй зээлийн авлага, хувь хүнээс авах авлагуудыг барагдуулах ажил зохион байгуулан ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх”, гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн дансанд бүртгэлтэй зээлийн авлага, хувь хүнээс авах авлагыг барагдуулах ажил зохион байгуулж үлдэгдлийг баталгаажуулан ажиллах

3.2.2 Илрүүлэлт: ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн морины барианы засварын ажил, Жаргалант багийн конторын барилгуудыг данс бүртгэлд бүртгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 4.1.24.“төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг; нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6. Анхан

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Морины барианы засварын 16.9 сая төгрөгийн хөрөнгө, Жаргалан багийн контор 59.8 сая төгрөг нийт 76.8 сая үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ажиллах.*

3.2.3 Илрүүлэлт: ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-д гэрээг байгуулан урьдчилгаа төлбөр олгож байна мөн гэрээний хувийг харилцан адилгүй хувиар байгуулан ажиллаж байгаа зөрчлүүд илэрлээ. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй, журмын заалтыг мөрдөж ажиллах*

3.2.4 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний ажлуудад хөтөлбөр боловсруулан батлаагүй, хөтөлбөрийн хүрэх түвшинг боловсруулан ажиллаагүй зөрчлүүд байна. Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ гэсэн журмын хэрэгжилтийг ханган ажиллах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлуудын гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож, хөтөлбөр боловсруулан ажиллах,

3.2.5 Хоршоо хөгжүүлэх сан болон Чандмань хөгжил сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хувь хүмүүст олгосон зээлийг төлүүлэх арга хэмжээ зохион байгуулан хяналт хэрэгжүүлэн ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1-д "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Хувь хүмүүст олгосон зээлүүдийг тухай бүр зээлийн эргэн төлөлтийн дагуу төлүүлэн, хугацаа хэтэрсэн зээлүүдийг холбогдох газарт нь уламжилж ажиллах;*

3.2.6 Хоршоо хөгжүүлэх сан болон Чандмань хөгжил сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Данс бүртгэлд бүртгэлтэй авлага, зээлийн хүү, алдангийг нэг бүчлэн хийж данс бүртгэлд тусган ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар" Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1-д "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Данс бүртгэлд бүртгэлтэй авлага, хүүгийн тооцоог нэг бүчлэн хийж авлагын тооцоог тулган баталгаажуулах;

3.2.7 Татварын орлого бүрдүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд газрын төлбөр, малын тоо толгойн албан татварын орлого, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр хураамж зэрэг нийт татварын орлогыг 33,357.8 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн, орлогыг төлөвлөгөөг тасалсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;" , 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг бүрдүүлэх талаар Төрийн байгууллага, албан хаагчдын ажлын уялдаа хариуцлагыг дээшлүүлэх, орлогыг бодитой төлөвлөх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мян.төг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10				
ХХСан	Зээлийн хүүгийн авлага үр дүнгийн тайланд бүртгээгүй	1	3,155.0	1	3,155.0			1	3,155.0				
ОНХС	Урьдчилсан гарсан зардал болон байгууллагад төлөх өглөг зөрүүтэй илэрхийлсэн.	2	45,772.8	2	45,772.8			2	45,772.8				
Үндсэн хөрөнгө	УТХО-н хөрөнгөөр бий болсон хөрөнгө ЗДТГ-н барилгын үнийн зөрүү бүртгээгүй	1	247,628.1	1	247,628.1			1	247,628.1				
Нийт дүн		4	296,555.9	4	296,555.9			4	296,555.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мян.төг)

Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Орлого	Орон нутгийн татварын орлогыг бүрдүүлээгүй, нэр төрлөөр нь тасалсан	1	33,357.8					1	33,357.8		
ХХСАН	Хувь хүмүүст олгосон зээлийг төлүүлэх арга хэмжээ зохион байгуулан ажиллагаагүй	1						1			

Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан											
ХХСАН	Данс бүртгэлд бүртгэлтэй авлага, хүүгийн тооцоог нэг бүчлэн хийж ажиллаагүй	1						1			
ОНХС	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажлуудаас захиалагчийн хяналтын зардлыг суутган тооцолгүй санхүүжилтийг бүрэн олгосон	1	3,469.70	1	3,469.70						
ОНХС	Данс бүртгэлд бүртгэлтэй зээлийн авлага, хувь хүнээс авах авлагуудыг барагдуулан ажиллаагүй тооцооны үлдэгдлийн баталгаа хийгээгүй байна	1	76,811.0					1	76,811.0		
ОНХС	Данс бүртгэлд морины барианы засварын ажилд 16.9 сая, Жаргалант багийн контор барих 59.8 сая нийт 76.8 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй байна	1	76,856.30					1	76,856.30		
ОНХС	ОНХС-аар хэрэгжүүлж байгаа ТАХ-д гэрээг байгуулан урьдчилгаа төлбөр олгож байна мөн гэрээний хувийг харилцан адилгүй хувиар байгуулсан ажиллаж байна.	1						1			
ОНХС	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлуудын гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож, хөтөлбөр боловсруулан батлан ажиллах, хүрэх түвшин хүрсэн түвшинг тухай бүрт хэлэлцэн ажиллаагүй	1	15,013.00					1	15,013.00		
Нийт дүн		8	205,507.8	1	3,470.0	-	-	7	202,037.8	-	

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		